

**ЖИБЗУНДАМБА ХУТАГТЫН САН, ШАВЬ НАРЫН  
ӨРИЙН АСУУДАЛД (XIX-XX ЗУУНЫ ЭХЭН)**

С.ДУЛИАМЖАВ

*МУБИС-ийн докторант*

**Товч агуулга:** Хятадын худалдаа-мөнгө хүүлэл нь албан татвартай уялдаатай байв. Ар Монгол Манжийн эрхшээлд орсноор Жибзундамба хутагтын шавь нарын гаргах алба нэмэгдэж, ноогдсон албыг залгуулахын тулд Хятадын худалдаачид-мөнгө хүүлэгчдээс өндөр хүүтэй мөнгө, бараа зээлэн авч байв. XIX-XX зууны эх гэхэд Жибзундамба хутагтын сан, шавь нар нь ихээхэн хэмжээний өртэй болсон байв. Тухайлбал, 1862-1903 онд Их сангийн өрийг төлөхөд шавийн нэг отгоос жилд дунджаар сэвэг цай 1-26, мөнгө 308-5642 лан, гүү 1-16, хонь 56-71, морь 15-39-ыг тус тус гаргаж хятадын пүүс, иргэнд өгч байсан нь төлөх өр хэд дахин нэмэгдэж байсан нь харагдана. Сурвалжийн мэдээнүүдээс үзэж байхад хутагтын шавь нар нь Их Хүрээний жасууд, Богдын үржүүлэх сан, Оросын дэлгүүр, пүүсээс илүү хятадын пүүс, иргэнтэй зээлийн худалдааг хийдэг байв. Чин улсын засгийн газраас хятад худалдаачдад эд, бараа, мөнгө зүйлийг жилийн 36%-ийн хүүтэй монголчуудад зээлдүүлж байх хуулийг гаргаж гурван жилийн дотор эс төлбөл дахин гэрээ хийж, үржсэн хүүг хамт бодож шинэ мэт гэрээ байгуулах эрхийг өгчээ. Зээлийн тогтоосон хүү бэлэн мөнгөний зээлд хэрэгжиж байснаас бараа, эд зүйлийн хүүд хэрэгжиж байгаагүй юм. Хятадын пүүс, иргэн малыг тухайн үеийн зах зээлийн үнээс доогуур авдаг, хэлсэн үнэд өгдөг байсан гэх зэрэг нь алдангид оруулж сан, шавь нарыг өртэй болгож байв.

**Түлхүүр үг:** Жибзундамба хутагт, шавь, Хятадын худалдаа-мөнгө хүүлэл, пүүс, өр, зээл, хүү, мөнгө, цай

XVII зууны сүүлчээр Монгол оронд Хятадын худалдаа мөнгө-хүүлэл нэвтэрч, XX зууны эхэн хүртэл монголчуудын ахуй амьдралд олон талаар нөлөөлөх болсон. Энэ асуудлаар эрдэмтэд судлан олон бүтээлүүд<sup>1</sup> туурвижээ. Эдгээр бүтээлүүдэд Богдын сан, шавь нарын өрийн талаар тэмдэглэсэн байдаг. Эрдэмтэн А. Очир

<sup>1</sup> Санждорж, М. *Халхад Хятадын мөнгө хүүлэгч худалдаа нэвтэрч хөгжсөн нь*, Улаанбаатар: 1963; Очир, А. *Монгол Хятадын худалдааны харилцаа. (XIX-XX зууны эхэн)*, Улаанбаатар: 1995; *Монгол Улсын түүх*, Боть IV, Улаанбаатар: 2004; Насанбалжир, Ц. *Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911)*, Улаанбаатар: 1964

“1908 онд Их шавийн бүх өр 3300000 лан хүрчээ. Эдгээр өрийг төлөгч нар нь шавь ард байв”<sup>2</sup> хэмээн бичжээ. Ц. Насанбалжир “Богдын сан орлоготой байсан боловч зардал нь түүнээс дутахгүй их байв. Иймд хятадын худалдаа мөнгө хүүлэгчдээс хүүтэй мөнгө зээлдэн авч өр төлбөр тавьж уул өрийг төлөхөөр шавь нар ардаас удаа дараа олон зуун мянган лан мөнгө татварлан гаргуулж ард олныг хоосруулж байв”<sup>3</sup> хэмээжээ. Шавь нар хятадын пүүс болон иргэнээс мөнгө, бараа, эд зүйлсийг зээлэн авч байсныг Монгол Улсын Үндэсний Төв Архивын баримтуудад олонтоо дурдсан байдаг. Бид өмнөх үеийн эрдэмтдийн судалгаанд нэмэр болгохоор Монгол Улсын Үндэсний Төв Архив, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн Хүрээлэнгийн гар бичмэлийн санд хадгалагдаж буй баримт мэдээнд тулгуурлан Жибзундамба хутагтын сан\*, шавь нарын хятадын пүүс, иргэнд төлж байсан өрийн тухай өгүүлэе.

Шавь нар нь зээл авах болсон шалтгаан нь: нэгдүгээрт, Халх Монгол Чин улсын эрхшээлд орсноор шавь нарын нийлүүлэх алба нэмэгдэх болсонтой холбоотой юм. Тухайлбал, Манжийн хаанд гөрөөсний мах нийлүүлэх (гахай, зүр), Манжийн хааны сүм хурлын алба (жасаанд оролцогсдын зардал), өртөөний алба, цэргийн түр бэлтгэл сургуулилтад оролцогсдын зардал, Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайдын газрын зардал хэрэглэлийг нийлүүлэх албууд нэмэгдсэн. Дээрх албуудыг товч тодруулъя. Нэгдүгээрт, Манжийн хаанд гөрөөсний мах нийлүүлэх (гахай, зүр). Төр гэрэлтийн 8 он буюу 1828 оноос “Жил бүр өвөл цагт барих гахай зүр\*-ийг тусгайлан хүн гаргаж агнуулахыг зогсоож, харьяат 2 аймаг (Түшээт хан, Сэцэн хан С. Д), Шавь харуулын газарт дагнуулахаар”<sup>4</sup> тогтжээ. Үүнээс хойш Жибзундамба хутагтын шавь нар дээрх 2 аймагтай хамтран Манжийн хааны хүндэтгэлийн зоогт барих гахай, зүрийн албыг тогтмол нийлүүлэх болжээ. Сурвалжид: Бадаргуулт төрийн 17 он буюу “...1891 онд ...харьяат 2 аймгаас гахай 16, 16, шавиас 12 гахай, зүр 9-өөдийг бэлтгэн гаргуулсан”<sup>5</sup> хэмээснээс үзэхэд шавь нар гахай, зүрийг аль тарганыг шилж сонгон агнаж, гэдэс дотор, зүрх, элэг, бөөр, өөхийг бүрнээр цэвэрлэн боож тогтсон хугацаанд нь хүргэх үүрэг бүхий байв. Хоёрдугаарт, Манжийн хааны сүм хурлын алба (жасаанд оролцогсдын зардал). Хамба номун хан, Эрдэнэ шанзудба нар жасаанд оролцохоор явахад тэдгээрийн замд хэрэглэх уналга ачлага, хүнс, мөнгийг шавийн отог, багуудад онуулан хуваасныг дараах хэдэн оноор жишээ болгон үзье.

<sup>2</sup> Очир, А. *Монгол Хятадын худалдааны харилцаа. (XIX-XX зууны эхэн)*, Улаанбаатар: 1995, 90

<sup>3</sup> Насанбалжир, Ц. *Жибзундамба хутагтын сан, Түүхийн судлал* 13-14. Улаанбаатар: 1970. 152

\* Хутагтын сан-Гадаад, Дотоод үндсэн хоёр сангаас бүрэлддэг.

<sup>4</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Түшээт хан аймгийн жанжны жасааны фондын баримтын данс. (1732-1911). ХМ-10. Д-1. ХН-2762. т. 27

\* зүр-эм бор гөрөөс

<sup>5</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Сэцэн хан аймгийн чуулган даргын фондын баримтын данс. (1737-1911). ХМ-31. Д-2. ХН-3865. Нугалбар. 3

Хүснэгт № 1. Жасаанд оролцогсдын зардал хэрэглэлийг шавийн отог, багуудад<sup>6</sup> онуулан хуваасан байдал

Он	Отог, баг	Сэвэг цай	Сул цай	Мөнгө (лан)	Тэмээ
1879	136	1948	790	1400	115
1883	137	1889	55520	1675	162
1885	136	1879	103135	1503	50
1887	138	1552	17683	6210	
1891	139	1622	44922	6491	164

Отог, багуудаас сэвэг цай 9167, мөнгө 17279 лан, тэмээ 491-ыг гаргуулжээ. Дурдан буй онуудад шавийн нэг отгоос жилд дунджаар сэвэг цай 11-14, мөнгө 10-45 ланг хураан авч байжээ. Гуравдугаарт, өртөөний алба, Сайшаалт ерөөлт хааны зарлигаар Сайшаалт ерөөлтийн 16 он буюу 1811 онд Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамнаас Хөтөл долон, Тал долон, Модон гурван өртөөдийн "... Улаа бэлтгэх албаны хүн юм зэрэг зүйлийг Халхын 4 аймгаас бүгдээр 3 жил гаргуулж, Жибзундамба хутагтын шавь нарын дотроос 3 жил гаргуулж жасаалан бэлтгэж шийтгэтүгэй. Үүнийг хууль болгогтун"<sup>7</sup> хэмээн албан ёсны шийдвэрийг гаргаснаас хойш Жибзундамба хутагтын шавь нар нь Халхын 4 аймагтай хавсран дээрх өртөөдөд албан журмаар алба хаах болжээ.

Тал долон, Хөтөл долон, Модон гурван 3 өртөөний хавсарга улааны морь, тэмээ, хонь, мөнгө<sup>8</sup>-ийг шавийн отог, багт онуулж хуваасныг дараах хэдэн оноор жишээ болгон үзье.

<sup>6</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-590. т. 2-10а, ХН-679. т. 2-11а, ХН-717. т. 2-11, ХН-771. т. 17-26, ХН-913. т. 24-33

<sup>7</sup> Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг. Гучингуравдугаар дэвтэр. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-7, т. 52-52а

<sup>8</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-197, 121, 1051, 1334, ХМ-85. Д-1. ХН-335, 465, ХМ-86. Д-1. ХН-4022, ХМ-85. Д-1. ХН-744, 945, 1110, 1504, ХМ-86, Д-1, ХН-7827

Хүснэгт № 2. Жибзундамба хутагтын шавийн отог, багуудаас дээрх өртөөдийн хавсарга улааг гаргасан байдал:

Он	Отог, багийн тоо	Сэвэг цай	Сул цай	Лан	Цэн	Пун	Тэмээ	Морь	Хонь
1813	102						145	260	
1825	112			5951	525				
1850	62			524	11	14			
1856	101						297	457	
1862	131	3396	54448	16304	543	425	294	1178	
1874	136	1896	52882	22765	424	560	358	985	700
1880	137			13143	623	635			
1886	137	1713	50215	30840	682	634	360	1000	700
1892	141	1519	48992	37194			360	1000	700
1898	146	521	49600	15026	634	620	333	668	762
1910	145	1793	54065	71730	484	320	360	1000	1000
1911	145			21454	1164	1084			

Шавийн отог, багуудаас сэвэг цай 11224, мөнгө 256805 лан, тэмээ 2507, морь 6548, хонь 3862-ыг бэлтгэн гаргуулжээ. Дурдан буй онуудад нэг отгоос жилд дунджаар мөнгө 8-225 лан, тэмээ 2-3, морь 2-8-ыг гаргуулжээ. Дөрөвдүгээрт, цэргийн түр бэлтгэл сургуулилтад оролцогсдын зардлыг нийлүүлэх, “Манж нар монголыг цэргийн түшиц газраа болгох, ашиглах үүднээс XVIII зууны II хагасаас Улиастайн газар дөрвөн аймгийн эрчүүдийг цуглуулан их ав хоморго явуулж, цэрэг эрийг сурган боловсруулах дасгал бэлтгэл хийх”<sup>9</sup> болжээ. “Тийнхүү жил бүр Улиастайд авлан боловсруулах нь алс холын 2 аймагт чирэгдэлтэй учир 1786 онд Их Хүрээний газар Түшээт хан, Сэцэн хан аймгийг, Улиастайд Засагт хан, Сайн ноён хан аймгийг авлан боловсруулахаар”<sup>10</sup> болов. Энэ үеэс Жибзундамба хутагтын шавь нь Түшээт хан, Сэцэн хан аймгийн цэргүүдийг Их Хүрээний газар авлан боловсруулах буюу цэргийн түр бэлтгэл сургуулилт хийхэд “авын газрын газарч, цагдан сэргийлэх цагдаа, Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын тамгыг залж явах саадагтай хиаг хоол хүнс, майхан, унах, ачих уналгатай нь хамт гаргах”<sup>11</sup> болжээ.

Сайшаалт ерөөлтийн 23 он буюу 1818 онд авлан боловсруулахад шавийн отог, багуудаас 40 өдрийн хэрэглэх хүнс зүйл майхан, хөтөл, унах, ачих морь, малыг гаргуулахад “сайдуудтаны хэрэглэх хонь 40, тамгын газрын Журган (Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам)-ы бичээч нэг бүрт нэг, нэг нийт хүнсний хонь арваад, 2 бошгын хүнсний хонь 7, бүгд хэрэглэх 74 хонь”<sup>12</sup> болж байжээ. Тухай үед хонь 1 лангийн ханштай байсан бөгөөд 74 хонь гэхэд 74 лан мөнгө болж байсан аж. Тавдугаарт, Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газрын зардал хэрэглэлийг

<sup>9</sup> БНМАУ-ын түүх, Боть. II, Улаанбаатар: 1968. 166

<sup>10</sup> БНМАУ-ын түүх, Боть. II, Улаанбаатар: 1968. 166

<sup>11</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-362. Нугалбар. 10

<sup>12</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-382. Нугалбар. 32

нийлүүлэх алба, 1761-1783 он хүртэл Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газрын зардал хэрэглэлийг Жибзундамба хутагтын шавь, Түшээт хан аймаг хамтран гаргаж байв. “Яамны дүрэм”-д “Амбасын (Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдууд) өртөө ба аливаа хэрэглэл зүйлийг хоёр аймаг (Түшээт хан, Сэцэн хан С. Д), шавь (Жибзундамба хутагтын шавь С. Д) гурван газраа онуулан тэгшлэн ... хуваамуй”<sup>13</sup> хэмээснээс үзэхэд хожмоо сайдын газар өргөжин тэлэхийн хэрээр зардал мөнгө их гарч Сэцэн хан аймгаас нэмэн гаргадаг болсон аж.

Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газрын хүнс болоод түлээ нүүрсэд Жибзундамба хутагтын шавь нараас хэдий хэмжээний зардлыг гаргаж байсныг Түгээмэл элбэгтийн 9 он буюу 1859 оны жишээгээр харуулъя. Манж амбаны хэрэглэсэн хонь, түлээ, нүүрс зэрэгт: “...шавиас хонь 38, үүний үнэ хөлс 15855 цай”<sup>14</sup> хонь нэг бүрийн үнэ 417 цай, “... түлээ 471 мод, түүний үнэ 5730 цай”<sup>15</sup> мод нэг бүрийн үнэ 12 цай, “худалдаж аваад хүргэсэн нүүрсний үнэ 198 араг болсны үнэ 4328 цай”<sup>16</sup> араг нэг бүрийн үнэ 21 цай, “нарс мод 89 тэрэг түүний үнэ 1335 цай”<sup>17</sup> тэрэг нэг бүрийн үнэ нь 15 цай. Энэ бүгдийн үнэд шавиас хураасан цай бүгд 27248 болж байв. Манж амбаны хэрэглэсэн хонь, түлээ, нүүрс зэргийн үнэд шавийн нэг отгоос дунджаар 200 цайг гаргаж байжээ.

Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайдын суух албаны гэр, хашаа, байшинг засахад багагүй зардал гарч байсан бололтой. Тухайлбал: Бадаргуулт төрийн 12 он буюу “1886 онд шавиас гаргаваас зохих 200 лан мөнгийг тооны ёсоор гаргаж 4 анги боож тайж Намжилдондог сайдуудтаны яамнаа хүргэв”<sup>18</sup> хэмээжээ. Жил бүр Түшээт хан, Сэцэн хан, Шавь гурван газраас Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газрын гэр, байшин, хашааг засахад 200, 200 лан мөнгө нийт 600 лан мөнгийг тогтмол гаргаж 8 сарын шинийн нэгэнд хүргэх үүрэг бүхий байв.

Хоёрдугаарт, Жибзундамба хутагтын харьяат сүм хийд олширсон нь шавь нар нь зээлийн худалдааг хийх шалтгаан болж байв. Тухайлбал, Жибзундамба хутагтын шавь нар нь 182519 онд хутагтын харьяаны Баруун хүрээ, Зүүн хүрээ, Эрдэнэ цоржийн хүрээ, Бибилэгийн хүрээ, Эрдэнэ зуугийн жас, Майдарын сүм, Авидын сүм, Далай ээжийн шүтээн, Дархан эмчийн шүтээн, Баруун хүрээний бага жас, Эрдэнэ зуу, Ноён цоржийн шүтээн гэсэн 12 сүм хийдэд сэвэг цай, зулын тосын албыг барьж байсан бол 191020 онд Эрдэнэ номун ханы хүрээ, Эрдэнэ сэцэн ноёны аймаг, Дэчинпунцоглин, Ганданлэгшидчойлин, Түгээмэл ивээлт, Сайныг бадруулагч, Мянган бурхан, Цагаан төгрөг, Буян үйлдэх цэнгэлдэх, Гайхамшигт тухлагт,

<sup>13</sup> Яамны дүрэм. т. 19а. МУҮНС гар бичмэлийн хөмрөг

<sup>14</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-1538. т. 3а

<sup>15</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-1538. т. 5а

<sup>16</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-1538. т. 6а

<sup>17</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-1538. т. 7

<sup>18</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-3. ХН-617. Нугалбар. 3

<sup>19</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-120

<sup>20</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-1502 \*нэг жин-600гр

Чүлтэмжанчивлин, Занхан, Өглөгийг бадруулагч сүмүүд нэмэгдэн 25 сүм хийдэд алба барих болжээ. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам, Жибзундамба хутагтын Гадаад сан, Жибзундамба хутагтын Дотоод сан зэрэг хөмрөгүүдэд хадгалагдаж буй баримтуудыг шүүн үзэхэд 1825-1910 оны хооронд Жибзундамба хутагтын шавь нар нь дээрх сүм хийдүүдийн хурал номын зардалд зориулан сэвэг цай 2547, зулын тос 56555 жин\* (33933 кг)-ыг бэлтгэн гаргаж байжээ. Шавь нар нь албыг төлж чадахгүйд хүрсэн тохиолдолд Их хүрээний зарим нэг дацангуудын хурал номын зардал хэрэглэлийг хорогдуулан тогтоож, хурлын зардлыг дацангуудын жас болоод Их сангаас гаргуулж шавь нарын албыг хөнгөвчлөх үе байв. Тухайлбал, Түгээмэл Элбэгтийн 2 он буюу 1852 онд "... олон шавийн хүн мал, олон шавийн тахилын цай маш их хасагдаж одоо их төлөв 2000 гаруйхан сэвгийн хөлөөр албан үйлдэж VII дүрийн Жибзундамба хутагтыг залахын элдэв хэрэглэлийг бэлтгэхээс гадна Их сангийн газраас олон иргэнд төлөх цай мөнгөний өр үлэмжхэний дээр бас олон дацангуудын хурал номын элдэв хэрэглэлийг мөн бэлтгэсээр байх бөгөөд уг сэвгийн тоо цөөхөн болж элдэв зарлага хүрэлцэхгүйн учир Богд эзнийг залж ирэх хүртэл ... Цанид, Жүд, Эмч нар, Бадамзориг, Зурхай, Майдар, Ламиран зэрэг 8 дацангуудын жасаа хурал ба элдэв үйлийг хэрэглэлийг VII дүрийн Жибзундамба хутагтыг залан ирэх хүртэл цөм өөр өөрийн жасаас хэрэглүүлэх"<sup>21</sup> шийдвэрийг Эрдэнэшанзудбын яамнаас гаргажээ. Гэтэл Цанид, Жүд дацангаас бусад нь зардлыг гаргаж чадахгүйгээ мэдүүлжээ. Дашчоймбил, Гунгаачойлин, Жүд, Зурхай, Эмч нарын зэрэг бусад дацангуудын зардлыг "... 6 сар Их сангаас, 6 сар мөн дацангийн жасаас гаргуулах"<sup>22</sup>-аар болжээ. Мөн хурал номын дээл, хэрэглэлийг дацангийн жасаас гаргуулах, дацангийн эвдэрсэн, хэмхэрсэн, оёулах, үдүүлэх зүйлийг Их сангийн газар авч ирэх, Гунгаачойлин дацангийн сар бүрийн шинийн нэгэнд хурах Цэдэрлхам, 15-нд хурах Дончид, Сонсгоод зэрэг номын тахил, манзыг Их сангаас гаргуулжээ. Гуравдугаарт, хутагтуудын тоо олширсон. Тодруулбал, Зарлигаар тодорсон Их шавийн тамга бүхий 7 хутагтаас гадна алба татвараас чөлөөлөгдсөн эрх дарх бүхий хутагтын тоо өссөөр байсан юм. Тухайлбал, шавь нар нь 1825 онд Жибзундамба хутагтын харьяаны алба татвараас чөлөөлөгдсөн "36"<sup>23</sup> хутагтад тахилын цай, зулын тосны албыг барьж байсан бол 1910 онд энэ тоо нэмэгдэн "118"<sup>24</sup> болж өсчээ. Шавь нар нь Жибзундамба хутагтын харьяа Манзушир номун хан, Хамба номун хан, Мэргэн хутагт, Эрдэнэ хамба номун хан, Хүүхэн хутагт, Мэргэн бандида, Далай хутагт нарын зэрэг олон хутагт, хамба, цорж нарт 1825-1910 оны хооронд сэвэг цай 2737, зулын тос 38920 жин (23352 кг)-ыг барьсан байна. Дөрөвдүгээрт, Их санд барих алба нэмэгдсэн. Тухайлбал, шавь нар нь Их санд 1849-190925 сэвэг цай 35074, зулын тос 784211 жин (470526 кг), саалийн үнээ 18938, хонь 14705, хомтой

<sup>21</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-250. т. 1-2

<sup>22</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-251. т. 1-2а

<sup>23</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-120, 163,201, 222, ХМ-86. Д-1. ХН-1314, ХМ-85. Д-1. ХН-295, 317, 343, 463, ХМ-86. Д-1. ХН-3651, ХМ-85. Д-1. ХН-678, 710, 860, 944, 1026, 1164, 1220,1308,1502

<sup>24</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-1502

<sup>25</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-218, 249, 272, 293, 311, 357, 387, 415, 452, 512, 592, 659, 716, 820, 912, 990, 1079, 1143, 1200, 1270, 1477 \*нэг бан-60 гр

тэмээ 9769, түлээ 300192 үхэр тэрэг, өвс 3103 үхэр тэрэг, сүү 562994 жин (337796 кг), аарц 81905 жин (49143 кг)-ыг бэлтгэн өгч байжээ. Тавдугаарт, ган гачиг зэрэг байгалийн бэрхшээлийн улмаас. Тухайлбал, Төр гэрэлтийн 5 он буюу 1825 онд “... Үржүүлэх тэмээг захируулсан захирч Гомбоцэрэнгийн өргөсөн бичигт ... Үржүүлэх тэмээ нутагласаар ирсэн Түшээт хан аймгийн хувь нутагт Вантаны хошуу ба Түшээ гүн засаг Ванчиндорж нарын хэдэн хошууны нутаг дор хэдэн он дор бороо орсонгүй гачигдаж, өвс ургасангүй хуучин үлдсэн хог өвсийг нэгэнт идэж дуусгаад энэ зэрэг хошууны ган гачиг оногдож, үлдсэн буй эцэнхий туранхай малыг амь ульжуулахын эрхээр ийш тийш сарнин нүүж, өөр бусад чуулган дор орж өдөр өнгөрүүлэн явжухуй. Хамт нутаглан явсан үржил тэмээ ялгалгүй ган гачиг дор тохиолдоод хүч мах олж чадсангүй... учир энэ он намар цаг шавийн харьяат ардыг Түшээт хан аймгийн засаг Дондогдорж, Сэцэн хан аймгийн жанжин бэйл танай хошуунд хуваан нутаглуулсан ... хэдэн өрхийн тэмээчин сайн бэлчээрийг олсон боловч харьяат нутгийн ард худаг усыг бөглөн гачигдуулсан”<sup>26</sup> хэмээжээ. Энэ мэт шалтгаануудын улмаас ноогдсон албуудыг залгуулахын тулд шавь нар нь хятадын пүүс, иргэн, Оросын худалдааны пүүс, дэлгүүр, үржүүлэх сан, жасаас мөнгө болон бусад хэрэгцээт зүйлийг өндөр хүүтэй зээлэн авдаг байв.

### Жибзундамба хутагтын шавь нарын өр ба зээлийн хүү

Чингийн төр хятадын худалдаа, мөнгө хүүлэгчдийг Монголд орж ирэхийг шууд дэмжчихээгүй билээ. Тухайлбал, 1757 онд Манжийн төрөөс Хятадын худалдаачдыг “... зээлээр худалдаа хийвэл зээлээр худалдсан бараа, мөнгийг албанд хураах ба худалдаачдад хүнд ял торгож, уг газарт хүргүүлэх”<sup>27</sup> тухай хуулийг гаргажээ. Мөн Сайшаалт ерөөлтийн 11 он буюу 1806 онд Чингийн төрөөс монгол хүнийг хятадуудтай өр тавихыг хориглосон хуулийг дахин гаргажээ. Энэ тухай сурвалжид: Хятад худалдаа тэдэнд төлөх өр, Монгол хүнийг хятадтай өр хийхийг хориглосон зэрэг асуудлаар харилцсан нугалбар, Эрдэнэ сэцэн далай шанзудбын яамны бичигт: “... шавийн аливаа хүн өр тавих үгүй зэрэг явдлыг урьд удаа бүр дарга нар дор зарласныг тушаан тэмдэглэжэхүй. Эдүүгэ бас зарим ард иргэдээс өр хийж будилаан болох дор хүрсэн нь харьяат дарга, мэдээч нар өөр өөрийн отгийн ардыг сайнаар эс захирсанаас үүдэх тул үүнийг дарга, мэдээчдэд ухуулан дахин тушаан үүнээс хойно өөрийн отгийн ардын иргэдээс өр хийлгэхгүй байх учрыг өрх дараалан хүн бүр сайтар зарлатугай. Хэрвээ юм авах хүн буй бөгөөс даруй бараа худалдаа авахуултугай. Урьдын адил хайш яайш зарлан өр тавьж зээлэн будилаантахуй дор хүргэвээс дарга, мэдээчин ба зээлэн авсан хүнийг хэрхэвч хэлтрүүлэхгүй цээрлэл үзүүлэн шийтгэмүй”<sup>28</sup> хэмээжээ. Эрдэнэ шанзудбын яамнаас Чингийн төрийн гаргасан хуулийг хэрэгжүүлэхийг шаардаж байсан хэдий ч шавь нар хүрээ, хийдийн хурал номын зардал болоод Манжийн төрд залгуулж байсан зарим нэг албуудыг тасалдуулахгүйн тулд Хятадын худалдаачид мөнгө-хүүлэгчид, пүүсүүдээс өр тавин зээлийн худалдааг хийсээр байв. Жибзундамба хутагтын харьяат хутагт

<sup>26</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-473. Нугалбар. 7

<sup>27</sup> Тэнгэрийг тэтгэсний ба Сайшаалт ерөөлт оны чухал хэргийн дэвтэр. МУҮНС гар бичмэлийн хөмрөг

<sup>28</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-203. Нугалбар. 11

хувилгаад, сүм хийдүүд Чингийн төрд зарим нэг албыг залгуулж байв. Тодруулбал, Жибзундамба хутагтын харьяат хутагт хувилгаадаас Тал долон, Хөтөл долон, Модон гурван 3 өргөөний хавсарга улаа<sup>29</sup>-г бэлтгэхэд гаргасан зардлыг дараах хэдэн оны жишээгээр харуулъя.

Хүснэгт № 3. Жибзундамба хутагтын харьяат хутагт хувилгаадын өртөөнд гаргасан зардал

Он	Хутагт хувилгаадын тоо	Сэвэг цай	Сул цай	Лан	Цэн	Пун	Тэмээ	Морь
1856	8					7	15	
1862	16	71	5235	372	16	61	6	22
1874	21	27	6500	325	92	65	2	15
1880	15			1024	90	59		
1886	17	44	4785	809	86	89		
1892	16	12	2480	266	50	40		
1898	7	1		41	41	18		
1910	16	12	4510	505	52	30		

Дурдан буй онуудад шавийн харьяа хутагт хувилгаадаас өртөөний албанд сэвэг цай 195, мөнгө 3387 лан, тэмээ 15, морь 52-ыг гаргажээ. Мөн Бадаргуулт төрийн 9 он буюу 1883 онд Улиастайн цэргийн хэрэгцээнд хоёр аймаг, шавь гурван газраас 1500 хомтой тэмээ гарган бэлтгэхэд "...шавиас 500 хомтой тэмээ (нэг бүрийн хөлс мөнгө 12 лан), улаач 70 (хүн тутмын хөлс мөнгө 6 лан), бүрэн хэрэглэлтэй майхан 7 (нэг бүрийн хөлс мөнгө 5 лан) мөн майхан ачих хомтой тэмээ 14 уналгын бага насны тэмээ 70 (нэг бүрийн хөлс мөнгө 7 лан) бас ачлагын хомтой тэмээ 35 (нэг бүрийн хөлс мөнгө 12 лан), захирах түшмэл 5 хүн (хүн тутмын хүнс мөнгө 12 лан), бүрэн хэрэглэлтэй майхан 5 (хүн нэг бүрийн хөлсний мөнгө 5 лан), уналгын бага насны тэмээ 5 бас ачлагын хомтой тэмээ 15, хөтөл хүн 10 (хүн тутмын хүнс мөнгө 6 лан), эд нарын уналгын бага насны тэмээ 10 бас ачлагын хомтой тэмээ 5, ерөнхийлөн дагаж захирах түшмэл 1 (хүнс мөнгө 12 лан), бүрэн хэрэглэлтэй майхан 1, уналгын бага насны тэмээ 1, хомтой тэмээ 3, хөтөл хүн 2, уналгын бага насны тэмээ 2, сэвэг цай 1891, сул цай 54030, мөнгө 9078 лан, 607 цэн, 568 пун<sup>30</sup>-г гаргажээ. Үүнийг шавийн 135 отог, баг, 2 сүм (Буянцэнгэлдэх сүм, Цагаан төгрөгийн сүм)-тэй хамтран гаргаж байв.

Чингийн төр Тэнгэрийг тэтгэсний 26 он буюу 1761 онд "хятад худалдаачдад эд бараа мөнгө зүйлийг жилд 36 хувийн хүүтэйгээр Монголчуудад зээлдүүлээд гурван жилийн дотор өрийг нэхэн авч байхыг хуулиар бататгажээ"<sup>31</sup>. Энэ нь сарын хүүг 3 хувиас хэтрүүлж болохгүй гэж заасан хэрэг бөгөөд зээлдэгч 3 жилийн дотор авсан

<sup>29</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-1334, Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-335, 465, ХМ-86. Д-1. ХН-4033, ХМ-85. Д-1. ХН-744, 945, 1110, 1504

<sup>30</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-660. т. 2-9а

<sup>31</sup> Очир, А. *Монголын феодализмын нийтлэг онцлогийн зарим асуудал*. Монголын феодализмын хөгжилд Хятадын худалдаа мөнгө хүүллийн нөлөө. Улаанбаатар: 1987. 95

\* нэг лан-37,3 гр, (нэг лан мөнгө тухайн үедээ нэг эм хоньтой тэнцэж байв.) \*нэг цэн-3,73 гр

зээлээ төлөх ёстой. Хэрэв төлж чадахгүй бол уг өрийг шинэ тавьсан өр мэт болгон гэрээ хийж, төлөх хугацааг дахин 3 жилээр тогтоодог байжээ.

“1796 онд Манжийн засгийн газар хятад худалдаачдад Халхын хошуудаар одоож худалдаалахыг албан ёсоор зөвшөөрчээ”<sup>32</sup>. Үүнээс хойш Монголд хятадын худалдаа-мөнгө хүүлэл эрчимтэй дэлгэрчээ.

Жибзундамба хутагтын шавь нарын хятадын пүүс, иргэнээс зээлэн авч байсан мөнгөний зээлийн хүүг тодруулъя. Бидэнд олдсон баримтад тэмдэглэснээр тухайлбал, Бүрэн засагчийн 12 он буюу 1873 онд VIII дүрийн Жибзундамба хутагтыг угтан залахыг харгалзуулан илгээх 49 цэргийн хэрэглэлийг бэлтгэхэд 8 цэрэг, нэг хөтөл хүний хэрэглэлд шавиас “бүрэн хомтой атан тэмээ 18, нэг бүрийн үнэ 23 лан”, морь 36, нэг бүрийн үнэ 13 лан, хүнсний мөнгө 450 лан, даавуун майхан нэгийн үнэ 15 лан, тогоо нэг бүрийн үнэ нэг лан, 6 цэн\*, тулга нэг бүрийн үнэ 8 цэн, хайч нэг бүрийн үнэ 2 цэн, шанга нэг бүрийн үнэ 2 цэн... үүнээс дээш бүгд нийлж 1717 лан мөнгийг хүрээний худалдааны иргэн Пайда, Хавчигбаярт хэмээн 2 пүүсийн иргэн лугаа хэлэлцэж энэ он 3 сараас сар тутам лан бүрийн 3 пун\* хувийн хүүтэй тушаахаар тогтож Пайдагийн пүүснээс 817 лан, Хавчигбаяртын пүүснээс 900 лан”<sup>33</sup> мөнгө авч уг хэрэглэлийг нийлүүлж байсан байна. Тэгвэл Пайдагийн пүүсээс 817 лан мөнгө зээлэхэд сарын хүүдээ 24 лан, 5 цэн, 1 пун, жилийн хүүдээ 294 лан, 1 цэн, 2 пун өгчээ. Харин Хавчигбаяртын пүүсээс 900 лан мөнгө зээлснээс сарын хүүдээ 27 лан, жилийн хүүдээ 324 лан өгсөн байна. Бүгд 1717 лан мөнгөний сарын хүү 51 лан, 5 цэн, 1 пун, жилийн хүү 618 лан, 1 цэн, 2 пун болж байна. Шавь ард Хавчигбаярт, Пайда нарын пүүсэд үндсэн эх мөнгөтэйгөө нийлээд нийт өгөх мөнгө 2335 лан, 1 цэн, 2 пунг төлнө гэсэн үг. Жилийн 36%-ийн хүүтэй зээлэн авсан байна.

Бас нэгэн баримтад: Бадаргуулт төрийн 19 он буюу 1893 онд шанзудба Дашдоржийн мэдүүлэх нь: “Уржинан жил ган гачиг тохиолдсон зэргийн учир Зан-Хуан-Хүгийн пүүсээс 5400 лан, Бээжингийн иргэн Ли-Сан-гаас 7600 ланг тус тус сар тутам 3 пун хүүтэй зээлэн авч хэрэглэсэн. Эдүүг тушаалын да лам Бадамдорж нар Бээжингийн өндөр Баянмөнхийн пүүснээс нэг түм\* нэг мянган ланг лан бүр сар тутам 2 пун 8 ли\*, бас иргэн Ли-Сангаас нэг түм 4150 ланг лан бүр сар тутам 3 пун ... хүүлж авъя хэмээсэнд Хүрээний сайдаас гарын бичигтэй бол өгмүй хэмээн хэлсэн. Да лам Батмөнх захиа бичиг өгснийг үзэж сайдуудтанд учрыг хэлж, гар бичиг хүргүүлсэн дор 2 түмэн ланг лан бүр 2 пун, хүүтэй тус тус зээлэн авч хэрэглэв”<sup>34</sup> хэмээжээ.

Мөн ган гачиг тохиолдсоны улмаас Зан-Хуан-Хүгийн пүүсээс шавь ард 5400 лан мөнгө зээлснээс сарын хүүдээ 162 лан, иргэн Ли-Сангаас 7600 лан мөнгө зээлснээс сарын хүүдээ 228 лан мөнгө төлнө. Энэ нь сарын 36% хүүтэй зээл байв. Харин да лам Бадамдорж нарын хүмүүс өндөр Баянмөнх, иргэн Ли-Сангаас 2 түмэн (20000)

<sup>32</sup> Очир, А. Монгол Хятадын худалдааны харилцаа (XIX-XX зууны эхэн). Улаанбаатар: 1995. 21

\* нэг пун-0,37 гр

<sup>33</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-3107. т. 59-60

\* нэг ли-37,3 мг

\* түм-10000

<sup>34</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-840. Нугалбар. 8

ланг зээлсний сарын хүүдээ 400 ланг өгнө. Энэ нь жилийн 24%-ын хүүтэй зээл авсан гэсэн үг. Баримтаас үзэхэд шавь ард, да лам Бадамдорж хоёрт олгосон зээлийн хүү ялгамжтай байгаа нь тухайн хүний нэр хүндтэй холбоотой байсан болов уу.

Жибзундамба хутагтын шавь нар хутагтын санд хэрэглэх 5000 лан мөнгийг Бадаргуулт төрийн 28 он буюу 1902 онд “Хүрээний баруун этгээд дор худалдаалан суугаа Пайдагийн пүүсээс сар тутам лан бүрийг 3 пун хүүтэй авч эсэргэн жил зуны сүүл сард эх мөнгийг\* үржүүлсэн хүүгийн\* хамт төлөн”<sup>35</sup> өгөхөөр болжээ. Жилд хүүдээ 1800 ланг өгнө. Эх мөнгө үржүүлсэн хүүгийн хамт бүгд 6800 лан болно. Жилийн 36% хүүтэй зээл байсан аж.

Бараа бүтээгдэхүүний зээлийн хүү мөнгөний хүүгээс илүү байв. Тухайлбал, Хятадын худалдааны Лүн Цин Гао хэмээх пүүс Бадаргуулт төрийн 27 буюу 1901 онд “... ноос жин бүрийг 4 пун мөнгөөр бодож ... ноос муу аваас сольж өгөх, тогтоосон хугацаанаас хожигдуулах, дутагдуулах ахул ноосны жин бүрт 7 пун 5 ли мөнгөний торгууль хүлээлгэж байжээ”<sup>36</sup>. Ноос өгөх хугацаа хэтэрсэн тохиолдолд худалдааны иргэн Лүн Цин Гао үндсэн авах мөнгөн дээрээ жин бүрт 3 пун 5 ли-г нэмж хүүлэн авч байжээ.

Хятадын пүүс болоод иргэн малыг хэрхэн үнэлэн авч байсныг энд товч дурдъя. XIX зууны эхээр Улиастайд Да-Шин-Күйгийн пүүс “морь ба шар үхэр тус бүрийг 8 лан, тэмээг 22 лангаар үнэлж байхад Бадарын пүүс “морь, үхэрийг 7 лан, тэмээг 20 лангаар тус тус үнэлж байсан бол XIX зууны сүүлчээр Их Хүрээн дэх “Пайдагийн пүүс адууг 961 цай\* (цайг ланд шилжүүлбэл тухайн үеийн ханшаар 6 лан 4 цэн, 6 ли, 6 ху, 6 си)-ээр, Баяртын пүүс 1000 цайгаар “<sup>37</sup> (6 лан, 6 цэн, 6 пун, 6 ли, 6 ху, 6 си)-ээр тус тус үнэлж байжээ. Тухайлбал, Бүрэн засагчийн 9 он буюу 1870 онд Дархадын 3 отгийн албаны цай, мөнгөнд авчирсан 2 зүйл малыг худалдаалахад: “Пайдаагийн пүүсэд дарга Цэвэгдоржийн отгийн малаас адуу 206, нэг бүр 900 цай (нэг адууг 6 лангаар, бүгд адууг 1236 лан)-гаар, хонь 1068-ыг нэг бүр 135 цай 1 ли 4 ху 4 си-ээр (9 цэн буюу бүгд хонийг 961 лан, 2 цэн)-ээр, дарга Гүржавын отгийн малаас Пайда, Ногоон 2 пүүсэд адуу 282, нэг бүр нь 961 цай (бүгд 1804 лан, 8 цэн)-ээр, Пайдагийн пүүсэд хонь 992 нэг бүр 125 цай 1 ли 5 ху-аар (нэг хонийг 8 цэн, 3 пун, 3 ли, 3 ху, 3 си, бүгд хонийг 826 лан, 6 цэн, 6 пун, 3 ху, 3 ли)-ээр, дарга Цэвэгжавын отгийн малаас адуу 210 нэг бүр нь 962 цай (6 лан, 4 цэн, 1 пун, 3 ли, 3 ху, 3 си,)-ээр, Пайдагийн пүүсэд хонь 1088, нэг бүр 136 цай 1 ли, 3 ху, 8 си”<sup>38</sup> (9 цэн, 6 ли, 6 ху, 6 си, бүгд хонийг 986 лан, 4 цэн, 5 пун, 3 ли, 3 ху, 3 си)-ээр худалдаалсан нь бүгд 1074570 цай (7163 лан, 8 цэн) болж байж. Тэр үед 150 шар цай нэг лан мөнгөтэй тэнцэж байжээ. XIX зууны сүүлчээр Их Хүрээн дэх хятадын пүүсүүд адууг 6 лан, хонийг 1 лан ч хүрэхгүй ханшаар авч байжээ. Тухайн үед хонины зах зээлийн үндсэн өртөг нь “1 лан 5 цэн”<sup>39</sup>-гээс 3 лан<sup>40</sup>”-гийн

<sup>35</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-3. ХН-714. Нугалбар. 4 \*эх мөнгө-анх зээлсэн мөнгө \*үржсэн хүү-хүүндээ өгөх мөнгө

<sup>36</sup> Насанбалжир, Ц. Жибзундамба хутагтын сан. 13-14. Улаанбаатар: 1970. 151

\* шар цай-шахмал цайг 8 хуваасны нэг. Хуучин цагийн нэгж болох цаасанд боосон задгай цай.

<sup>37</sup> Санждорж, М. *Халхад Хятадын мөнгө хүүлэгч худалдаа нэвтэрч хөлжсөн нь*, Улаанбаатар: 1963. 61

<sup>38</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-2312. т. 95-99а

<sup>39</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-744. т. 10

<sup>40</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-1504. т. 10а

ханштай байв. Сурвалжуудаас үзэхэд монголчууд малыг пүүс, иргэний хэлсэн ханшаар л өгдөг байжээ. Тухайн жил тоолуулсан малынхаа хэдэн хувийг пүүст өгч байсныг нарийвчлан гаргавал, тухайлбал, Дархадын дарга Гүржавын отог тус онд “адуу 2058, хонь 5702, тэмээ 77, үхэр 660”<sup>41</sup>-ыг тоолуулж байснаас 282-ыг пүүст өгсөн нь бүх адууны долооны нэг, бүх хонины зургааны нэг нь болж байв.

Хүрээ хийдийн жасууд XVIII зууны үеэс Хятадын худалдаа мөнгө хүүлэлийн нөлөөгөөр мөнгө хүүлэх болжээ. Хүрээ хийдийн жасууд мөнгө хүүлэх болсон нь дараах нөхцөл байдалтай холбогдоно. Үүнд: Жасуудаас алба татвар авдаггүй. Хүрээ хийдүүд өргөжин тэлж, нэр хүнд олохын хэрээр сүсэгтэн олны өргөл барьцаар жасуудын сан хөмрөг зузаарах болсон. Мөн түүнчлэн буян бодож сүсэгтэн ард хүрээ хийдийн малыг үнэ төлбөргүй хариулан, маллаж байсан зэргийн улмаас жасуудад мөнгөний хуримтлал үүсэж мөнгө, цай, бараа гэх зэргийг бусдад хүүлэх болжээ. XX зууны эхэн дэх Монголын хүрээ хийд нийтдээ “7000 орчим жасатай байснаас Их Хүрээнд 224 жас”<sup>42</sup> байв. Энэ үеийн хүрээ хийдүүдийн жасын хүүг Их Хүрээний Дархан эмч, Вангай, Сангай, Шүтээн зэрэг аймгуудын жасын мөнгө хүүллийн жишээн дээр авч үзье. Бүрэн засагчийн 3 он буюу 1864 онд Эмч нарын дацангийн жасаас “Дархан эмчийн аймгийн тойн Санждоржид 50 лан мөнгийг нэг сар тутам лан бүр 3 пун хүү”<sup>43</sup>-тэй зээлдүүлж байжээ. Энэ нь жилийн 36%-ийн хүүтэй зээл байв.

Бүрэн засагчийн 12 он буюу 1873 онд “ард Дашням Их Хүрээний Вангай аймгийн жасаас 2280 шар цайг сар тутам 114 шар цайн хүүтэй”<sup>44</sup> зээлэн авчээ. Ард Дашням 100 шар цай тутамд 5 шар цайг нь хүүдээ өгч байжээ. Тэрээр жилийн хүүдээ 1368 шар цайг өгөх бөгөөд эх мөнгөтэй нийлбэл жилдээ 3648 шар цайг өгөх болж байна. Тус Вангай аймгийн зээлдүүлсэн шар цайг тухайн үеийн ланд шилжүүлэн бодвол ард Дашням 15 лан 2 цэн мөнгийг сарын 7 цэн, 6 пунгийн хүүтэй зээлжээ. Ард Дашням жилийн хүүдээ 9 лан, 1 цэн, 2 пун мөнгийг өгнө, мөн тус жас “2 хунз цайг\* 2 сарын 10 чулуун цай”<sup>45</sup>-гаар хүүлж байж. 2 хунз цайны нэг сарын хүү нь 5 чулуун цай болж байна. 2 хунз цайг зээлсэн хүн жилдээ 60 чулуун цай өгнө гэсэн үг юм. Мөн “20 хатуу цайг\* зээлэхдээ нэг сарын нэг хатуу цай”<sup>46</sup>-гаар хүүлж байв. Тэгвэл 1873 онд Вангай аймгийн жас жилийн 60 %-ийн хүүтэй зээл өгч байжээ.

Их Хүрээний Сангай аймгийн жасаас Бадаргуулт төрийн 16 он буюу 1890 онд “...Шүтээний аймгийн гэлэн Шарав 100 лан мөнгийг лан нэг бүрийг сард 4

<sup>41</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-420

<sup>42</sup> Пүрэвжав. С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. Улаанбаатар: 1978. 135

<sup>43</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Дархан эмчийн аймаг. (1818-1911). ХМ-95. Д-1. ХН-164. т. 2

<sup>44</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Вангай аймаг. (1819-1908). ХМ-100. Д-1. ХН-5. т. 3а

\* хунз цай- саванд хийсэн 27-36 ширхэг цай.

\* чулуун цай-булан цай. Нэг чулуун цай 30 шар цайтай тэнцэнэ.

<sup>45</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Вангай аймаг. (1819-1908). ХМ-100. Д-1. ХН-5. т. 3а

\* хатуу цай-шахмал цай.

<sup>46</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Вангай аймаг. (1819-1908). ХМ-100. Д-1. ХН-5. т. 4

нун”<sup>47</sup>-ээр хүүлэн авчээ. Гэлэн Шарав нэг жил болоход хүүдээ 48 лан мөнгийг өгнө гэсэн үг. Мөн онд “Баргын аймгийн тойн Дашдондов, Дашдорж нар тус аймгийн жасаас 300 хатуу цайг сар тутам 12 хатуу цай”<sup>48</sup>-ны хүүтэй Зоогой аймгийн гэлэн Даржаа мөн аймгийн Рэнцэн, Дондовдорж нараар даалгаж зээлэн авчээ. Жилийн хүүдээ бүгд 144 хатуу цай өгнө. Сангай аймаг хатуу цайг жилийн 48% хүүтэй зээлж байсан аж. Дархан эмчийн аймгийн жасыг бодвол Сангай аймаг, Вангай аймгуудын жасуудын зээлийн хүү илүү байна. Үүнээс үзэхэд Их Хүрээний жасуудын бусдад зээлүүлсэн мөнгөний хүү харилцан адилгүй байсан бололтой. Хятадын мөнгө хүүлэгч худалдаачдын зээлийн хүүгээс Их хүрээний жасуудын зээлийн хүү илүү байсан аж. Иймээс шавь нар нь хятадын мөнгө хүүлэгч худалдаачдаас зээл авах нь илүү байжээ.

Тухайн үед Оросын худалдааны пүүс, дэлгүүрүүдийн мөнгөний зээлийн хүү бага байсан аж. Тухайлбал, “Бадаргуулт төрийн 29 он буюу 1903 оны 4 сарын 25 ... шавийн отгуудаас Оросын ... бүгд 6 пүүсэд төлөх өр хүү үржсээр 3 түм гаруй лан мөнгөний тоон дор хүрч”<sup>49</sup> байжээ. Тухайн үед Оросын худалдааны пүүс дэлгүүрүүд нэг цөлхөөв\* цаасыг сарын нэг мөнгөний хүүтэй зээлж байжээ. Тодруулбал, Бадаргуулт төрийн 30 он буюу 1904 онд Жибзундамба хутагтын шавь нараас Оросын худалдааны пүүсээс “... түмэн цөлхөөв (10000) цаас нэг бүр сар тутам нэг мөнгөний хүүтэй 12 сараар”<sup>50</sup> зээлэн авч байжээ. Жибзундамба хутагтын шавь нар Оросын пүүст сарын хүүдээ 100 төгрөг, жилийн хүүндээ 1200 төгрөг өгнө гэсэн үг. Жилийн 12 %-ийн хүүтэй зээл байсан аж. Оросын пүүс, дэлгүүрүүдийн мөнгөний зээлийн хүү бага байсныг нэгдүгээрт, бараа, бүтээгдэхүүнээ холоос тээвэрлэн авчирдаг, хоёрдугаарт, бараа, бүтээгдэхүүний чанар, эргэлт, гуравдугаарт, хятадууд нь монголчуудад элбэг байдаг зүйлийг авдаг, Оросууд нь элбэг биш зүйлийг авдаг байж болох юм. Жишээ нь Оросууд ангийн үс гэх мэт хятадууд мөөг, аргал гэх зэрэг, дөрөвдүгээрт, Оросын пүүс, дэлгүүрүүдийг бодвол Хятадын пүүс, иргэн хүү, хугацааны хувьд төлбөрийн уян хатан нөхцөлтэйгөөр зээлийг олгодог байсан зэрэг олон хүчин зүйлүүдтэй холбон үзэж болох юм. Оросын мөнгөний зээлийн хүү бага байсан ч хутагтын шавь нар тэднээс зээл авах нь бага байсан. Үүнийг Манжийн төрийн бодлоготой холбон ойлгож болох юм.

Богдын үржүүлэх сангийн зээлийн хүү ямар байсан талаар дурдъя. Бүрэн засагчийн 9 он буюу 1870 онд Жибзундамба хутагтын отог, багуудад “1324603 шар цайг хүү үржүүлэн”<sup>51</sup> зээлжээ. Мөн Жибзундамба хутагтын үржүүлэх сангаас “4000 лан мөнгө зээлэн авсан Сэцэн хан аймгийн бэйл Лаваанрэнцэнгийн дүү лам Чүлтэмийн санд төлөх өрийг хөөн төлүүлсүгэй”<sup>52</sup> гэх зэрэг баримтуудаас үзэхэд

<sup>47</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Сангай аймаг. (1878-1911). ХМ-115. Д-1. ХН-3. т. 2

<sup>48</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Сангай аймаг. (1878-1911). ХМ-115. Д-1. ХН-3. т. 3а

<sup>49</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-982 \*цөлхөөв-Оросын хуучны мөнгөний нэгж.

<sup>50</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-997. Нугалбар. 8

<sup>51</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-2691. т. 23-23а

<sup>52</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Сэцэн хан аймгийн чуулган даргын фондын баримтын данс (1737-1911). ХМ-31. Д-2. ХН-4267. Нугалбар. 12

Богдын үржүүлэх сан нь бусдад мөнгө, цайг хүү үржүүлэн зээлж байв. Энэ үед үржүүлэх сангийн мөнгөний зээлийн хүү ямар байсан талаар сурвалжид: Бүрэн засагчийн 10 он буюу 1871 онд засаг ноён Дугардорж, дагалт бичээч Буни-Очир нарт “... 1500 лан мөнгийг нэг сард лан бүр 3 пун”<sup>53</sup>-гийн хүүтэй зээлдүүлжээ. Ноён Дугардорж, бичээч Буни-Очир нар хутагтын үржүүлэх санд сарын хүүдээ 45 лан, жилийн хүүдээ 540 ланг өгнө. Эх мөнгөтэйгөө нийлээд жилдээ 2040 лан мөнгийг өгнө гэсэн үг. Жилийн 36%-ийн хүүтэй зээл байв. Мөн Богдын үржүүлэх сан нь атан тэмээ, тэрэгний шар үхрийг ачлага эдэлгээнд хэрэглүүлэн бусдад зээлээр зарж ашиг олж байв. Тухайлбал, Сайшаалт ерөөлтийн 24 он буюу 1819 онд “нэг тэмээг 30 лангаар үнэ тогтож”<sup>54</sup> бусдад зээлээр зарж байв. Тухайн үед тэмээний зах зээлийн үндсэн өртөг 20-22 лан мөнгө байсан болно. Нэг тэмээнд дунджаар “360-450 жин (216-270 кг) ачаа ачиж”<sup>55</sup> жин тээдэг байсан аж. Мөн 1819 онд Их хүрээний эрдэнэшанзудба Гомбожав, сангийн хамаг хэргийг байцаан шийтгэх засаг улсад туслагч гүн Цэвээндорж, да лам Лувсандэнзэн нараас Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газар явуулсан бичигт: “Оросоос торгож хураасан ... 3802 лан мөнгө... сангийн газар дор сайтар хадгалуулсан явдлыг мэдүүлэн өргөв”<sup>56</sup> хэмээжээ.

Богдын сан ийнхүү бусдад мөнгө, цай хүүлж, мөнгийг хадгалж орлоготой байсан ч зардал нь их байв. Хятад пүүст тавьсан өрнөөс гадна Бат-Оршил өргөх, Уул тайх, хүрээ хийдийн хурал номын зардал, Богдын дүрийг тодруулах, залах, жанч халах гэх зэрэгт орох зардал нь Их сангийн зарлагыг нэмэгдүүлж байв. Тухайлбал, Тэнгэрийг тэтгэсний 57 буюу 1792 онд IV Богдод Бат-Оршил өргөхөд “7 жин (4кг 200 г), бурам 120 жин (72 кг), үзэм 200 жин (120 кг), чихэр 120 жин (72 кг), улаан чавга 51 жин (30 кг), хар чихэр 51 жин (30 кг), хушга 51 жин (30 кг)”<sup>57</sup>-ыг Их сангаас гаргаж байжээ. Мөн Түгээмэл элбэгтийн 7 он буюу 1857 онд Хан Хэнтий уулыг тайхад тахилын зүйлд орох “... арвайн гурил 7 жин (4.2 кг), цагаан хүж 2 багц, самбай 10, цагаан будаа 2 шанага, хушга 2 шанага, цагаан гурил 2 жин (1 кг 200 гр), тос 2 жин, бурам 20 зүсэм, чавга 14 жин (8 кг 400 гр), арвай 30 жин (18 кг), шар цай 500”<sup>58</sup>-г Их сан гаргажээ. Тахилын зүйлс, чихэр, жимс амттан, асар, сүйх тэрэг, хадаг, торго гэх зэрэг чамин үнэт зүйлийг Их сан нь гаргадаг байв. Мөн VIII Богдын үед түүний сонирхон тэжээж байсан амьтдын хоол тэжээлд багагүй зардал гарч байв. Тухайлбал, Бадаргуулт төрийн 23 он буюу “...1897 онд нэг нохойн хоолонд өдрийн 2 жин (1кг 200г) мах, шар будаа өдрийн 1 жин”<sup>59</sup> (600 гр) өгч байжээ. Жилд 438 кг мах, 219 кг шар будаа, “12 хятад тахиа, нэг тогоруу,

<sup>53</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-790. Нугалбар. 27

<sup>54</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-390. Нугалбар. 1

<sup>55</sup> Таяама Шигэрү. Чин улсын үе дэх Монголчуудын нийгмийн байгуулал. Хөх хот. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо. 1988. т. 419

<sup>56</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-390. Нугалбар. 4

<sup>57</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1. ХН-20. т. 2

<sup>58</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911) . ХМ-86. Д-1. ХН-3972. т. 34а-35

<sup>59</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911) . ХМ-86. Д-1. ХН-6329. т. 3

нэг тоодогийн нэг өдрийн хоолонд шар будаа өдрийн 7 жин<sup>60</sup> (4 кг 200 гр). Жилд 1533 кг шар будаа, “Усны гахай 3-ын хоолонд мантууны сайн цагаан гурил 15 жин (9 кг), амт цаасан чихэр 7 жин<sup>61</sup> (4 кг 200 гр) жилд 3285 кг сайн цагаан гурил, 1533 кг цаасан чихэр орж байжээ. Нэг мантуунд 100 гр гурил орно гэж үзвэл нэг гахайд өдөрт 30 ширхэг мантуу буюу жилээр бодвол 10950 ширхэг мантуу, цаасан чихэр өдөрт 1 кг 400 гр. Жилд 511 кг, “нэг туулайн хоолонд арвай овьёос нэг, нэг жин (жилд 219 кг арвай, 219 кг овьёос), 2 тооройн хоолонд мах өдрийн нэг хөл<sup>62</sup>. Үүнийг жилээр бодоход 52 хонь болно. “8 сармагчны хоолонд лууван мантуу өдрийн 6, 6<sup>63</sup> (өдөрт 48 ширхэг лууван мөн тооны мантуу идэж байж). Энэ нь жилд 17520 лууван, мөн тооны мантуу болж байна. “...нэг хар гөрөөсний хоолонд шар будаа өдрийн 4 жин<sup>64</sup> (2кг 400 гр). Жилд 876 кг шар будаа, “22 нохойны хоолонд шар будаа 236 жин (141 кг 600 гр) мах 398 жин (238 кг 800 гр). Эдгээр нохой бүрд гэдэс 10 лан, шар будаа 6 лангаар бодож, гаргамуй<sup>65</sup> хэмээснээс үзвэл 22 нохойд өгөх мах жилд 51684 кг, гэдэс дотор 87162 кг болж байна. Тухайн үед зөвхөн шар будаа 40 жин (24 кг) нь нэг лан, нэг жин (600 гр) шар будаа нь 2 фун 5 ли үнэ ханштай байсан гэж бодоход тэдгээр амьтдын хоол, тэжээлд мөнгө их орж байсан аж.

Богдын тэжээж байсан зааны чимэг зүүлтийг хийхэд л гэхэд “хоргой, торго 17 бүхэл, 111 ам, урт хадаас 290 ширхэг, оёх утас 490 санж, залаа 90 санж, жонхуу, хөвөн<sup>66</sup> орж байв. Бадаргуулт төрийн 34 он буюу 1908 онд Богд гэгээнтний ордонд буй олон шувууны тэжээл самрыг бэлтгэхэд Хүрээний ойрх ууланд самар ургаагүй учир Амарбаясгалант хийдийн ойролцоо орших Бүрэн хан уулын ойр нутаглагсдаас “самар 50 дүү (900 кг)-г 50 цөлхөөв цаасаар<sup>67</sup> худалдан авчээ. Нэг дүү буюу 18 кг самрыг 1 цөлхөөв цаасаар 50 дүү самрыг нь 50 цөлхөөв цаасаар авч байсан аж. Харин “... Хутагт гэгээн өөд болбоос улаа шүүс хэмжээгүй<sup>68</sup> гаргуулж байв. Энэ мэт зарлага их гарч сангийн зарлага нь орлогоосоо давж Богдын сан хятад пүүс иргэдээс өр тавьж зээл авах болжээ. Тухайлбал, Бадаргуулт төрийн 24 он буюу 1898 онд Богдын гадаад, дотоод сангаас Хятадын нэр бүхий том, жижиг 50-иад пүүсэд 39991 лан мөнгөний өртэй байжээ. Тодруулбал, “Дэрсэн хөхийн пүүсэд 643 лан, Бээжин Хишигтийн пүүсэд 2613 лан, Бээжин Мишигтийн пүүсэд 1210 лан, Өндөр Баянмөнхийн пүүсэд 9014 лан, Бээжин Буянжагаагийн

<sup>60</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1710-1911). ХМ-86. Д-1. ХН-6329. т. 3а

<sup>61</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1710-1911). ХМ-86. Д-1. ХН-6329. т. 3а

<sup>62</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1710-1911). ХМ-86. Д-1. ХН-7717

<sup>63</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1710-1911). ХМ-86. Д-1. ХН-7846. т. 30

<sup>64</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1710-1911). ХМ-86. Д-1. ХН-7846. т. 30

<sup>65</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-7846. т. 30

<sup>66</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-6437

<sup>67</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам (1710-1911). ХМ-85. Д-3. ХН-748. Нугалбар. 7

<sup>68</sup> Их хүрээний шавийн яамны Халх журамын дүрэм. т. 3. МУҮНС гар бичмэлийн хөмрөг; Жалан-Аажав, С. Халх журам бол Монголын хууль цаазын дурсгалт бичиг. Улаанбаатар: 1958. 58

пүүсэд 6229 лан, Бээжин Бадрахын пүүсэд 1925 лан, Бээжин Настын пүүсэд 2449 лан<sup>69</sup> мөнгөний тус тус өртэй байв. 2 жилийн дараа Бадаргуулт төрийн 26 он буюу 1900 онд дээрх пүүсүүдэд төлөх өр 50000 лан хүрч байжээ. Тодруулбал, “Пайдагийн пүүсэд 8459 лан, 4 цэн, 4 пун, Ногооны пүүсэд 7907 лан, 3 цэн, 9 пун, Маагийн пүүсэд 3426 лан, 9 цэн, 9 пун, Зүүн бүдүүний пүүсэд 6672 лан, 9 цэн, 3 пун, Баруун бүдүүний пүүсэд 2311 лан, 3 цэн, 5 пун, Хархорхойн пүүсэд 339 лан, 3 цэн, 2 пун, Хуузын пүүсэд 3280 лан, 5 цэн, Бээжин Хишигийн пүүсэд 987 лан, 2 цэн, 2 пун, Дэрсэн хөхийн пүүсэд 718 лан, 4 цэн, Мухарын баруун пүүсэд 297 лан, Бээжин Бадрахын пүүсэд 1861 лан, 2 цэн, 5 пун, хагархай Далайн пүүсэд 73 лан, 2 цэн, Маймаагийн цагаан бичээчийн пүүсэд 5061 лан, 6 цэн, 4 пун, Бээжин Содномдаржаагийн хойд пүүсэд 1438 лан, 5 пун<sup>70</sup>-гийн өртэй байв.

Гэтэл 9 жилийн дараа буюу Хэвт ёсны тэргүүн он буюу 1909 онд Богдын сан дээрх нэр бүхий 50-иад пүүс, иргэнд төлөх нэг жилийн өр: Тодруулбал, “Бээжин Сономбаярт төлөх өр 35381 лан, Бээжин Мишигт төлөх өр 2432 лан, Бээжин Буянжаргалын баруун пүүсээс авсан юм нь мөнгөөр тооцвол 5725 лан, Бээжин Тин-Да-Хугаас 3344 лан мөнгө, Бээжин Баяртын урд пүүсээс 464 лан, Бээжин Түмэнбаярын пүүсээс авсан юмны үнэнд 1118 лан, Бээжин Сономдаржаагийн урьд пүүсээс авсан юмны үнэнд 460 лан, Бээжин Баяртын хойд пүүсээс авсан юмны үнэнд мөнгө 737 лан<sup>71</sup> бүгд 49661 лан хүрч байжээ.

Богдын сангийн Хятадын худалдааны пүүс, иргэдээс эзэлэн авсан өр жил ирэх тутам нэмэгдэж тэр их өрийг шавийн отог, багуудад онуулан хуваан төлүүлж байв. Энэ тухай Монгол Улсын Үндэсний Төв Архивын Манжийн үеийн Их шавийн эрдэнэ шанзавын яам, Жибзундамба хутагтын Гадаад сан, Жибзундамба хутагтын Дотоод сангийн хөмрөгийн баримтуудаас шүүн он дараалан бичихийг хичээсэн боловч дараах онуудыг тэмдэглэсэн нь олдсон болно.

<sup>69</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Дотоод сан. (1765-1911). ХМ-87. Д-2. ХН-34. Нугалбар. 8

<sup>70</sup> Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн. Хөмрөг-1. Ф-1. Д-1. ХН-641. т. 1-2; Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын дотоод сан. (1760-1911). ХМ-87. Д-1. ХН.34. Нугалбар. 8

<sup>71</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-7629. т. 3-107

Хүснэгт № 4. Хятадын пүүс болон иргэнд төлөх өрийг шавийн отог, багуудад онуулан хувааж байдал<sup>72</sup>

Он	Отог, багийн тоо	Сэвэг цай	Лан	Гүү	Хонь	Морь
1862	131	3418	53690			
1865	135	3087	98032			
1891	140	1864	43166			
1893	142	1443	87619	2297	9645	
1894	141	1193	63549			2204
1895	148	658	95339	1506	8297	
1897	145	722	69432			
1899	146	578	246741			
1903	142	237	801251	234	10209	5641

Дурдан буй онуудад шавийн отог, багуудад сэвэг цай 13200, мөнгө 1558819 лан, гүү 4037, хонь 28151, морь 7845-ыг онуулан хуваажээ. Шавийн нэг отгоос жилд дунджаар 1-26 сэвэг цай, мөнгө 308-5642 лан, гүү 1-16, хонь 56-71, морь 15-39-ыг тус тус гаргаж байсан гэсэн үг. Мөн Бадаргуулт төрийн 24 он буюу 1898 онд шавь нараас шар цай гэхэд л “2110926”<sup>73</sup>, Бадаргуулт төрийн 30 он буюу 1904 онд шавь нараас цаасан мөнгө буюу цөлхөөв “13520”<sup>74</sup>-ыг хураан авч байжээ.

Өрийг шавь нараар шаардан төлүүлж байв. Энэ тухайд: Хэвт ёсны тэргүүн он буюу 1909 онд “... Эдүүгээгээс харьяат олон шавь нар олон удаа үлэмж татвар албан ба цагийн гачиг, малын эмгэг элдэв дор хурч чармайж иргэн монголчууд дор хэд хэдэн зуун түмэн лангийн өр дутсаныг бидний газраас арга үүсгэн төлөх өрийг хугацаалан төлүүлэв”<sup>75</sup> хэмээнээс үзэхэд шавь нар, отог багууд оногдсон өрийг цаг тухайд нь төлсөөр иржээ.

Мөн Их сан өр, зээлээ Халх дөрвөн аймгуудаар төлүүлж байсан аж. Энэ тухай: Бадаргуулт төрийн 22 он буюу 1896 оны 7 сард Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газраас явуулсан бичигт: “... иргэн дор тавь илүү түмэн лангийн өр дутагдаж, гачигдахын туйл дор хүрсэн ... шанзудба, да лам нараас сангийн өр үлэмж хэмээн харьяат шавь нараас ойрхи жил дор дарцагаар татварлан авсан мөнгө 40 түмэн, 2800 илүү лан, морь 2600 илүү лан, гүү 1300 илүү лан, одоо бусад дор төлөх мөнгө 31 түм 5900 илүү лан ... Эдүгэ сан, шавь өр татвар хөрөнгө хохироод ... шашны хэрэглэлд гачигдаж, харьяат хурал номыг тасалдах дор хүргүүлж буй бөгөөд ... бидний газраас сонсож мэдсээр байж дуугуй суух дор бэрхийн тул дөрвөн аймгийн чуулганы дарга, туслагч жанжин нарт мэдүүлж “<sup>76</sup> туслахыг гуйсан бичгийг явуулжээ. Халх дөрвөн аймаг чуулган даргын газраас хэлэлцэн туслахыг зөвшөөрчээ. Зөвшөөрсөн

<sup>72</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ- 85. Д-1. ХН-334, 370, 913, 968, 987, 1024, 1086, 1125, 1201

<sup>73</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Дотоод сан. (1765-1911). ХМ-87. Д-2. ХН-34. Нугалбар. 8

<sup>74</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гдаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1. ХН-7024. т. 14а

<sup>75</sup> Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн. Хөмрөг-1. Ф-1. Д-1. ХН-585

<sup>76</sup> Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн Хүрээлэн. Хөмрөг-1. Ф-1. Д-1. ХН-581

шалтгаан нь Жибзундамба хутагт нь Халх бүгдээр тахисан ачит багш, тахилын их лам байсантай холбоотой байсан биз ээ.

Их сангийн Хятадын пүүс болон иргэн, Орост төлөх өр Бадаргуулт төрийн 31 он буюу 1905 онд "... иргэн Монгол, Төвд, Орос нараас хүү холбоотой авч аргацаан гүйцэтгэсээр бүхий нийлсэн өр 300 илүү түмэн ланд хүрсэн"<sup>77</sup> хэмээн Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн Хүрээлэнгийн гар бичмэлд тэмдэглэжээ.

Ийнхүү Жибзундамба хутагтын гадаад, дотоод сан өрөнд орсноор шавь нарын өөрсдийн төлөх өрийн дээр сангийн өрийг дарах алба нэмэгдэн шавь нарын амьдрал улам доройтож, тэдний аж ахуй үгүйрэн хоосроход хүрчээ. Шавийн отгийн дарга Галсанжав, шүүлэнгэ Шагдаржав нараас Бадаргуулт төрийн 28 он буюу 1902 оны 6 сарын 29-нд Их яамнаа өргөсөн бичигт: "... Манай харьяат отог, багаас Хятад, ... Орос нарт төлөх албаны өрийг ... буй бүхий хөрөнгө малаас хэр чинээгээр хичээн чармайж өгсөн боловч гүйцээсэнгүй. Эдүгэ отгийн бүгд өр мөнгө нэг түм 7600 лан, шар цай 8 бум, 4 түм 200 гаруй болох бөгөөд үүний дотроос бүгд 745 сул цайтай Нямдорж, зайсан Цэрэндорж нарын зэрэг 16 хүн цаг гачиг ба малын эмгэг зэргээр хохирч хөрөнгө чинээгээр маш ядуурч ноогдсон албаны өрийг огт төлж чадахгүйд хүрсэн бөгөөд одоо тэдний төлвөөс зохих дутсан албаны өр мөнгө 9730 илүү лан, шар цай 5 бум, 3 түм, 6400 илүү болмуй"<sup>78</sup> хэмээжээ. Тэдний хөрөнгө, мал эд хогшлыг шавхан өгсөн ч хүрэлцэхгүй, аргагүй албаны хэрэг тул харьяат отгийн тахилын цайтай, цайгүй хүмүүсээс хэр чинээг нь үзэж татварлан тулган тушаасан ч чадахгүйн учир Нямдорж, Цэрэндорж нарын 16 хүний тахилын цайг хасаж өгөхийг гуйсан бичгийг Эрдэнэшанзудбын яамнаа хүргүүлж байжээ.

Бас нэгэн сурвалжид: Бадаргуулт төрийн 29 он буюу 1903 оны 4 сарын 25. Эрдэнэ шанзудбын яамны алба хураасан, алба татварт өгөх малгүй, ядуурсан зэрэг асуудлаар харилцсан нугалбар бичигт: "Эдүгэ манай отгийн нийгмээр ойрхи хэдэн жилдээ цагийн гачиг ба хүн, малын үхэл, зовлон, албан татварын элдэв зүйл дор чармайсаар одоо эл албыг гүйцэтгэн барих аргагүй болсон нь нүд үзгэл илэрхий тул арга буюу албаны хэргийг гүйцэтгэхийг эрхэмлэж, манай отгийн сан ба ... бүгд 6 пүүсэнд төлөх өр хүү үржсээр эдүгэ 3 түм гаруй лан мөнгөний тоон дор хүрсэн бөгөөд эдгээр өрийг төлөх дор тэдний буй хөрөнгө малыг цөлмөн өгөв ч гүйцэтгэх аргагүй дор хүрсэн...отгийн 22 хүний тахилын цайг хасаж өршөөвөөс болох эсэх эсвээс тэдэн дор үүнээс хойш ноогдох албыг хэрхэвээс зохихыг тогтоон зааж, ухуулж, дагаж явуулах ажаамуу"<sup>79</sup> хэмээжээ. Дээрх асуудлуудыг хэрхэн шийдсэн баримтуудыг хараахан олж үзээгүй болно.

Шавь нар жилээс жилд ядууран хоосорч амиа ч тэжээх чадваргүй болсныг Эрдэнэшанзудбын яамнаас хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ тухай: Бадаргуулт төрийн 34 он буюу 1908 онд "... *Харьяат олон шавь нар нийтээр хөрөнгө чинээ ядуурсан байдал чанар нэг болжээ*"<sup>80</sup> хэмээжээ.

<sup>77</sup> Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн Хүрээлэн. Хөмрөг-1. Ф-1. Д-1. ХН-584. т.10

<sup>78</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-963. Нугалбар. 31

<sup>79</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-2. ХН-982

<sup>80</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ- 85. Д-2. ХН-1095. Нугалбар. 8

Улмаар шавь нарын амьдрал доройтон ядуурч байсан учир Хэвт ёсны тэргүүн он буюу 1909 онд шавийн харьяа эрх дарх бүхий хутагт, хувилгаад, Их хүрээний аймгуудын жас, зарлигаар нэр шагнасан шагнаагүй хутагтын харьяа сүм, хийд, хурлын жасуудаас алба гаргуулахыг Богд гэгээнтэн зөвшөөрсөн аж. Эрдэнэ шанзудбын яамнаас "... хэдийнээс харьяат олон шавь нар, олон отог, багийн үлэмж татвар албан ба цагийн гачиг малын эмгэг, элдэв дор хүчин чармайж иргэн монголчууд дор хэд хэдэн зуун түмэн лан өр дутсаныг бидний газраас арга үүсгэн дутсан өрийг хугацаалан төлөх ба элдэв албаны зарлигийг хэмнэн арвилж жил тутам гучаад түмэн лан гаргуулсан авч ... пүүсний зэрэг чухал газраас хүүтэй авч хэрэглэсэн энэ жил төлвөөс зохих болзоо бүхий мөнгө 50 илүү түмэн лан, мөн энэ жилийн дотор сан дор урьтал болгон зарцуулах 10 шахам түмэн лан ... дан ганц отог шавь дор тулгах дор хөрөнгө бүрмөсөн шавхагдаж, хойч өдөр олон хурал номын зэрэг чухал албыг залгамжуулан чадахгүйд хүрэх учир энэ удаа бидний Хамба, шанзудба нараас дараалан Журган (Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам) дор данс бүхий үгүй хутагт, хувилгаан мөн жас нар ба олон хүрээ, сүмийн цорж, лам нар жич зарлигаар нэр шагнасан үгүй сүм хурал, жасыг оролцуулан гаргуулах"<sup>81</sup>-ыг Богд гэгээнтэнээ айлтгасанд "олон дор нийгэмчлэн гаргуулж, хойчийн албан данс отог шавь нар дор өчүүхэн тус боллогтун"<sup>82</sup> гэсэн зарлигийг айлдаж, тэднээс алба гаргуулахыг албан ёсоор зөвшөөрч байсан ажээ.

## Дүгнэлт

Хятадын худалдаачид-мөнгө хүүлэгчид нь Монголын зах зээл дээр дангаар ноёрхож байсан байдлаа ашиглан хаах албаны нэр төрөл нэмэгдсэн, сүм хийд, хутагт хувилгаадын тоо олширсон, байгалийн бэрхшээл зэрэг шалтгаануудын улмаас оногдсон албаа төлж чадахгүйд хүрч байсан шавь нарт мөнгө, цай, эд барааг өндөр хүүтэй зээлдүүлж байв. Сурвалжийн мэдээнүүдээс үзэж байхад хутагтын шавь нар нь Их хүрээний жасууд, Богдын үржүүлэх сан, Оросын дэлгүүр, пүүсээс илүү хятадын пүүс, иргэнтэй зээлийн худалдааг хийдэг байв. Чингийн засгийн газраас хятад худалдаачдад эд, бараа, мөнгө зүйлийг жилийн 36%-ийн хүүтэй монголчуудад зээлдүүлж байх хуулийг гаргаж гурван жилийн дотор эс төлбөл дахин гэрээ хийж үржсэн хүүг хамт бодож шинэ мэт гэрээ байгуулах эрхийг өгчээ. Тэд энэ эрхээ давуу байдлаар ашигласан юм. Зээлийн тогтоосон хүүг бэлэн мөнгөний зээлийн хүүд хэрэгжүүлж байснаас бараа, эд зүйлийн хүүд хэрэгжүүлж байгаагүй аж.

Дурдан буй үеүдэд Их хүрээний жасууд мөнгө, цайг жилийн 48%-60% хүүтэй, Богдын үржүүлэх сан 36% хүүтэй, Оросын пүүс, дэлгүүрүүд 12% хүүтэй тус тус зээлдүүлж байжээ.

Их сан хятадын пүүс, иргэнд тавьсан өрнөөс гадна бусад зардлууд нэмэгдэн зарлага нь орлогоосоо давж өрөнд орсон байдаг. Их сан, шавь нарын тавьсан өрийг зааглаж тус тусад нь ялгах баримт хараахан олдоогүй учир өрийг нийтэд нь гаргасан болно. Их сан нь хятадын пүүс, иргэнд тавьсан өрөө шавь нараар төлүүлж байсан бөгөөд өөрийн өгөх өр дээр Их сангийн төлөх өр нэмэгдэн шавь нарын амьдрал улам доройтсоор байсан аж.

<sup>81</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэшанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-3. ХН-767. Нугалбар. 12

<sup>82</sup> Монгол Улсын Үндэсний Төв Архив. Манжийн үеийн Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-3. ХН-767. Нугалбар. 12

Хятад худалдаачид мөнгө-хүүлэгчид нь Манжийн төрийн дэмжлэгтэйгээр Монголд нэвтэрч, улмаар өргөжин Их сан, шавь нарын төдийгүй монголчуудын хэрэгцээ, сонирхолд нийцсэн бараа бүтээгдэхүүнийг сонгон авчирч чаддаг байсан. Мөн зээлийн барьцаа хөрөнгө шаардахгүйгээр төлбөрийн төрөл, хүү, хугацааны хувьд уян хатан нөхцөлтэйгөөр мөнгө, бараа бүтээгдэхүүнийг зээлж хүүлдэг, зээлийн хүү, хүүгийн хүүг өсгөн авч чаддаг байсан. Энэ байдал нь Их сан, шавь нарыг хятад пүүс, иргэнтэй зээлийн худалдааг давуу байдлаар хийлгэхэд хүргэсэн бөгөөд тэднийг их хэмжээний өрөнд оруулжээ. Мөн шавь нараас адуу, хонь малыг авахдаа тухайн үеийн зах зээлийн өөрийн өртгөөс доогуур авдаг. Шавь нар нь малыг пүүс, иргэний хэлсэн ханшаар өгдөг байсан ч оногдсон албыг цаг тухайд нь хааж, залгуулахад Хятадын пүүс, иргэний зээлийн худалдаа илүү нийцэхүйц байв. Их сан, шавь нарын хувьд XIX-XX зууны эхэн үе нь эдийн засгийн талаар хятадын худалдаачид мөнгө-хүүлэгчдийн хараат байдалд орсон үе байв.

## ABSTRACT

### **Regarding the debt issues of the disciples and fund of Jibzundamba Khutagt (Holy Highest Lama)**

(From 19<sup>th</sup> century to the beginning of the 20<sup>th</sup> century)

At the end of the 17<sup>th</sup> century Chinese trade and money lending business has entered and eventually occupied Mongolian market, thus left the people of Mongolia devastated until the beginning of 20<sup>th</sup> century. The power of Jibzundamba Khutagt has increased and the number of monks and miraculous monks increased, the simple people's taxes increased a lot and they had to borrow money and other necessary goods with high interest from Chinese moneylenders and companies to pay their taxes.

The reason why Chinese made loan trade was not only connected to the taxes, but also to make Mongolia as their colony and Manchurian economic policy.

Here they borrowed 817 “lan” silver and 900 “lan” from Khavchigbayart company and supplied to the soldiers. In this case, the borrowers paid back the 817 lan silver with monthly interest of 24 lan, 5 tsen\* and 1 pun\* and for annual interest they paid 294 lan, 1 tsen, 2 pun. But for 900 lan borrowed from Khavchigbayart company, they repaid 27 lan for the monthly interest and 324 lan for the yearly interest. In total, for 1717 lan silver, they repaid the loan with monthly interest of 51 lan, 5 tsen and 1 pun and for yearly interest they paid 618 lan, 1 tsen, 2 pun silver. It means that totally the disciples had to pay back 2335 lan, 1 tsen, 2 pun including first 1717 lan silver to the companies of Paida and Khavchigbayart. They received this loan with yearly 36%.

Then now let's compare the loan interest of Chinese moneylenders with loan interest of the funds of Great Khuree. In the archive facts, it is noted that ‘In 1873 or the 12<sup>th</sup> year of Buren Zasagch (the name of the year according to old Manchurian calendar), ‘Thefolk Dashnyam borrowed 2280 yellow tea with monthly interest of 114 yellow tea from the Fund of Vangai province of Great Khuree’. In this case the borrower borrowed the tea with 5 yellow tea interest per 100 tea bags. This way he had to pay 1368 yellow tea as an annual interest, in total 3648 yellow tea including the original borrowed tea. Vangai province fund gave the loan with 60% interest per year.

If we clarify the Multiplying Fundloan interest, the branch of foreign fund of Bogd: ‘In 187 or in 10<sup>th</sup> year of Buren zasagch, the Governor Dugardorj and typist Buni-Ochir borrowed ‘...1500 lan silver with monthly interest of 3 pun interest per lan’. It equals to the loan interest of 36% per year.

Money interests of Russian trade companies and shops were smaller compared to the Chinese money-lenders and Great Khuree Fund and Multiplying Fund of Bogd. At that time, Russian trade companies and shops used to lend one tsulkhuuv<sup>5</sup> paper with monthly one silver interest. For instance: In 1904 or the 30<sup>th</sup> year of Badarguult Tur, the disciple of Jibzundamba Khutagt borrowed... *10000 tsulkhuuv paper with monthly interest of one silver for 12 months from Russian trade company*. It means that the disciples of Jibzundamba Khutagt had to pay back 100 tugrik as a monthly interest and 1200 tugrik as an annual interest to the Russian company. We can understand the lower interest rate of Russian companies and shops was due to the Manchurian government policy, which restricts the impact and access of Russian traders and companies not to enter Khalkha Mongolia, especially the Manchurians preferred to let mostly Chinese traders enter Great Khuree (Great capital city).

Chinese traders took advantage of being dominated in Mongolian market alone and used to lend the disciples their goods and money with very high interest, who had shortage of the goods and money.

According to the source information, Chinese trade companies and citizens used to lend money with 24-36% annual interest, Great Khuree Funds used to lend money and tea with 48-60% annual interest. Above facts show that the loan interest of Great Khuree Funds was not smaller than Chinese traders and moneylenders. We might understand that loan trade was like this because of the absence of specific payment instruments in Mongolia during that time. Chinese traders used to engage in trade with the procedure of lending money with interest, when they bring the goods to Mongolia and it resulted the disciples having large debts that they cannot pay back.

## Ном зүй

### Архивын материал

1. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Түшээт хан аймгийн жанжны жасааны фондын баримтын данс. (1732-1911). ХМ-10. Д-1
2. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Сэцэн хан аймгийн чуулган даргын фондын баримтын данс. (1737-1911). ХМ-31. Д-2.
3. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их шавийн Эрдэнэ шанзавын яам. (1710-1911). ХМ-85. Д-1, 2, 3
4. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Гадаад сан. (1750-1911). ХМ-86. Д-1
5. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Жибзундамба хутагтын Дотоод сан. (1765-1911). ХМ-87. Д-1, 2
6. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Дархан эмчийн аймаг. (1818-1911). ХМ-95. Д-1
7. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Вангай аймаг. (1819-1908). ХМ-100. Д-1.
8. Монгол Улсын Үндэсний Төв Архив. Их хүрээний Сангай аймаг. (1878-1911). ХМ-115. Д-1

### Гар бичмэл

1. Их хүрээний шавийн яамны Халх журамын дүрэм. Монголын Үндэсний Номын Сан гар бичмэлийн хөмрөг [Шифр 8082/96]
2. Тэнгэрийг тэтгэсний ба Сайшаалт ерөөлт оны чухал хэргийн дэвтэр. [Шифр 2973/96]
3. Яамны дүрэм. [Шифр 2899/96]
4. Манжийн үед холбогдох баримт. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн Хүрээлэн. Хөмрөг-1. Д-1

### Судалгааны бүтээл

1. *БНМАУ-ын түүх*, Боть. II, Улаанбаатар: 1968
2. Жалан-Аажав, С. *Халх журам бол Монголын хууль цаазын дурсгалт бичиг*. Улаанбаатар: 1958
3. Насанбалжир, Ц. *Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911)*, Улаанбаатар: 1964
4. Очир, А. *Монгол Хятадын худалдааны харилцаа. (XIX-XX зууны эхэн)*, Улаанбаатар: 1995
5. Очир, А. *Монголын феодализмын нийтлэг онцлогийн зарим асуудалд*. Монголын феодализмын хөгжилд Хятадын худалдаа мөнгө хүүллийн нөлөө. Улаанбаатар: 1987
6. Пүрэвжав, С. *Монгол дахь шарын шашины хураангуй түүх*. Улаанбаатар: 1978
7. Санждорж, М. *Халхад Хятадын мөнгө хүүлэгч худалдаа нэвтэрч хөгжсөн нь*, Улаанбаатар: 1963
8. Таяама Шигэрү. *Чин улсын үе дэх Монголчуудын нийгмийн байгуулал*. Хөх хот. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо. 1988.
9. Насанбалжир, Ц. Жибзундамба хутагтын сан, *Түүхийн судлал* 13-14. 1970. 152